

НУУЦЛАЛЫН БОДЛОГО

ТА ҮЙЛЧИЛГЭЭГ АВАХЫН ӨМНӨ ЭНЭХҮҮ НУУЦЛАЛЫН БОДЛОГОТОЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЭСЭХИЙГ ХАРААТ БУСААР, БИЕ ДААН ШИЙДВЭРЛЭХИЙГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Энэхүү Нууцлалын бодлогоор "Мандал Дижитал Кредит" ББСБ ХХК (цаашид "ББСБ" эсхүл "Мэдээлэл хариуцагч" гэх), түүний Car Zeel гар утасны аппликейшн (цаашид "Апп" гэх)-д бүртгүүлсэн Хэрэглэгчийн хувийн мэдээллийг цахимаар олгосон зөвшөөрлийн үндсэн дээр цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, дамжуулах, устгахтай холбоотой харилцааг зохицуулна. Нууцлалын бодлогоор тухайлан зохицуулаагүй харилцаанд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Банк бус санхүүгийн байгууллагын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

Хэрэглэгч та энэхүү Нууцлалын бодлогыг сайтар уншиж танилцсан байх үүрэгтэй бөгөөд танилцаагүйгээс үүдэн гарах аливаа асуудалд Мэдээлэл хариуцагч хариуцлага хүлээхгүй болно.

Нууцлалын бодлогод тусгасан нөхцөлүүдийг бүрэн хүлээн зөвшөөрч байгаа тохиолдолд "Зөвшөөрөх" гэсэн хэсгийг идэвхжүүлснээр Мэдээлэл хариуцагчид Хэрэглэгчийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, дамжуулах, устгах зэрэгт зөвшөөрөл олгосон гэж үзнэ. Хэрэв та зөвшөөрөхгүй байгаа бол Аппыг ашиглах боломжгүй.

Нэг. Нэр томьёоны тодорхойлолт

1.1. "Хувийн мэдээлэл" гэж хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой мэдээллийг хэлнэ. Үүнд: хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он сар өдөр, төрсөн газар, оршин суугаа хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, зураг, цахим тодорхойлогч буюу холбоо барих мэдээлэл, бичиг баримтын хуулбар, санхүү, зээлтэй холбоотой бусад мэдээлэл багтана.

1.2. "Эмзэг мэдээлэл" гэж хүний үндэс угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа зэрэг онцгой хамгаалалт шаардсан мэдээллийг ойлгоно. ББСБ эмзэг мэдээллийг зөвхөн Хэрэглэгчийг таньж баталгаажуулах (жишээ нь: биометрик мэдээлэл)-д, хуульд заасан үндэслэлээр, шаардлагатай хэмжээгээр цуглуулж, боловсруулна.

1.3. "Мэдээлэл цуглуулах" гэж мэдээллийг олж авах, бүрдүүлэх, бүртгэх үйл ажиллагааг ойлгоно.

1.4. "Мэдээлэл боловсруулах" гэж мэдээллийг ангилах, хадгалах, дүн шинжилгээ хийх, хэрэглэгчийн хүсэлтээр өөрчлөх, устгах, сэргээх үйл ажиллагааг ойлгоно.

1.5. "Мэдээлэл ашиглах" гэж мэдээлэл цуглуулах, боловсруулахаас бусад хэлбэрээр Мэдээлэл хариуцагч үйл ажиллагаандаа хэрэглэх, дамжуулах болон мэдээлэлтэй танилцах үйл ажиллагааг ойлгоно.

1.6. "Мэдээлэл хариуцагч" гэж "Мандал Дижитал Кредит" ББСБ ХХК-ийг ойлгоно.

1.7. "Төхөөрөмжийн таних мэдээлэл" гэж Хэрэглэгчийн ашиглаж буй гар утас, төхөөрөмжийг тодорхойлох давхцалгүй код (device ID, advertising ID), push мэдэгдлийн token зэрэг Аппликейшний хэвийн үйл ажиллагааг хангахад ашиглагддаг техникийн мэдээллийг ойлгоно.

1.8. Дараах нэр томъёог Car Zeel Аппликейшний Үйлчилгээний нөхцөлд заасантай ижил утгаар ойлгоно: "ББСБ", "Апп", "Хэрэглэгч", "KYC / Харилцагчийг таньж мэдэх", "Биометрик мэдээлэл", "Скоринг", "Дижитал зээлийн гэрээ", "Баталгаажуулах код".

Хоёр. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үндэслэл, зорилго

2.1. ББСБ Хэрэглэгчийн хувийн мэдээллийг дараах зорилгоор цуглуулж, боловсруулж, дамжуулж ашиглана:

- Онлайнаар зээл авах хүсэлтийг баталгаажуулах, тооцоолол хийх, Аппаар үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх, үйлчилгээ үзүүлэх;
- Хэрэглэгчийг таньж баталгаажуулах (KYC);
- Хэрэглэгчтэй байгуулсан Зээлийн гэрээний хэрэгжилтийг хангах, төлбөрийн сануулга болон холбогдох мэдээлэл хүргэх;
- Аппликейшний систем хөгжүүлэлтийг тасралтгүй гүйцэтгэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх;
- Мэдээллийн технологи, хиймэл оюун ухааны тусламжтайгаар дүн шинжилгээ хийх, мэдээллийн үнэн зөвийг шалгаж баталгаажуулах, Хэрэглэгчийн санхүүгийн чадавхыг Скорингоор тодорхойлох;
- Залилан мэхлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх;
- Хууль тогтоомжид заасан бусад үүргээ биелүүлэх, эрх бүхий байгууллагын шаардлагыг хангах.

2.2. Хэрэв ББСБ Скоринг тооцоолол хийхэд гуравдагч этгээдийн программ хангамж, үйлчилгээ ашигладаг бол тухайн этгээдэд зөвхөн Скоринг тооцоолол хийхэд шаардлагатай мэдээллийг, зөвхөн тухайн зорилгоор ашиглуулах нөхцөлтэйгөөр дамжуулна.

2.3. Хэрэглэгч Аппыг ашиглахдаа энэхүү бодлогыг зөвшөөрснөөр дээрх зорилгоор мэдээлэл боловсруулахыг зөвшөөрч байна гэж үзнэ.

2.4. Мэдээлэл хариуцагч нь Үйлчилгээгээ сайжруулах зорилгоор Хэрэглэгчийн мэдээллийг нэмэлтээр цуглуулж болно.

Гурав. Цуглуулах, боловсруулах мэдээллийн жагсаалт

3.1. ББСБ Хэрэглэгчийг таньж баталгаажуулах, зээлийн хүсэлтийг бүртгэх зорилгоор дараах мэдээллийг цуглуулж, боловсруулна:

- Овог, нэр, регистрийн дугаар, төрсөн он сар өдөр, хүйс;
- Гар утасны дугаар, и-мэйл хаяг, Facebook хаяг, оршин суугаа хаяг, гэрийн хаяг;
- Иргэний үнэмлэхийн зураг, хуулбар, KYC баталгаажуулалтын явцад авсан сэлфи зураг;

- Ажлын газар, үйл ажиллагааны чиглэл, албан тушаал, мэргэжил, боловсрол, гэрлэлтийн байдал;
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээлэл болон орлого нотлох бусад мэдээлэл, өрхийн гишүүдийн тухай мэдээлэл гэх мэт ХҮР системээр дамжуулан баталгаажуулсан бусад мэдээлэл;
- Банкны дансны дугаар;
- Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа болон зээлжих зэрэглэлийн онооны лавлагаа;
- Хэрэглэгчийн бүртгэлд хамаарах нэвтрэх нэр, нууц үг, болон пин код;
- Хэрэглэгчтэй холбогдох боломжгүй тохиолдолд эсхүл яаралтай үед холбогдох 3 хүний овог, нэр, утасны дугаар, холбоо хамаарал болон улс төрд нөлөө бүхий этгээд эсэх эсхүл улс төрд нөлөө бүхий этгээдийн холбоотой этгээд эсэх гэх зэрэг мэдээллүүд. Хэрэглэгчтэй яаралтай үед холбогдох 2 хүний мэдээллийг оруулсан нь тус 3 хүнээс зөвшөөрөл олгосон гэж үзнэ;

3.2. Хэрэглэгч Үйлчилгээг ашиглах явцад үүсэх мэдээллүүд:

- Зээлийн гэрээ, зээлийн үлдэгдэл, төлөлтийн хуваарь, эргэн төлөлтийн түүх;
- Хэрэглэгчээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдол.

3.3. Үйлчилгээг сайжруулах, аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах мэдээллийг автоматаар цуглуулж болно:

- Аппликейшн суулгасан төхөөрөмжийн загвар, үйлдлийн систем, аппын хувилбар, Төхөөрөмжийн таних мэдээлэл, push мэдэгдлийн token;
- Аппликейшний хэвийн ажиллагааг хангах, эвдрэл (crash) илрүүлэх зорилгоор цуглуулагддаг техникийн лог, ашиглалтын статистик;
- Хэрэглэгчийн зөвшөөрсөн тохиолдолд байршлын мэдээлэл, камер, зурган сан (gallery)-д хандах зөвшөөрлөөр дамжуулан цуглуулагдах мэдээлэл;
- Аппд нэвтрэх нэр, нууц үг (масклагдсан хэлбэрээр);
- Хэрэглэгч үйлчилгээтэй холбоотой аливаа төрлийн ухаалаг төхөөрөмж ашиглаж Мэдээлэл хариуцагчийн цахим хуудас болон олон нийттэй харилцдаг сувгуудаар дамжуулан холбогдоход ашиглагдсан таны IP хаяг зэрэг мэдээллүүд;

Дөрөв. Аппликейшний зөвшөөрөл

4.1. ББСБ Car Zeel Аппликейшний хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Хэрэглэгчийн төхөөрөмж дээр дараах зөвшөөрлийг хүсэж болно. Хэрэглэгч тухайн зөвшөөрлийг өөрийн төхөөрөмжийн тохиргооноос хэдийд ч цуцлах эрхтэй:

- Камер — иргэний үнэмлэх, сэлфи зураг авах, баримт бичиг байршуулах зорилгоор;
- Зурган сан / файлын хадгалалт — бэлэн байгаа баримт бичгийн зургийг сонгож байршуулах зорилгоор;
- Байршил (Location) — Хэрэглэгчийн оршин суугаа газрыг баталгаажуулах, залилан мэхлэлтээс сэргийлэх зорилгоор;
- Мэдэгдэл (Push notification) — зээлийн төлөв, төлбөрийн сануулга хүргэх зорилгоор;

- Биометрик нэвтрэлт (хурууны хээ / царай таних) — төхөөрөмж дээрх нэвтрэлт бөгөөд ББСБ биометрик өгөгдлийг серверт хадгалахгүй.

4.2. ББСБ Хэрэглэгчийн хувийн мэдээллийг ашиг олох зорилгоор гуравдагч этгээдэд худалдахгүй, түгээхгүй, Үйлчилгээний хэрэгцээнээс гадуур аливаа ашиг олох зорилгоор ашиглахгүй.

4.3. ББСБ Хэрэглэгчийн хувийн мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу зөвхөн дараах тохиолдолд бусад этгээдэд дамжуулна:

- Монгол Улсын шүүхийн шүүгчийн захирамж гарсан;
- Прокурорын тогтоол гарсан;
- Хууль сахиулах байгууллагын шаардлагаар, мөрдөгчийн саналыг прокурор зөвшөөрсөн албан тоотыг үндэслэн;
- Маргааныг шийдвэрлүүлэх хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны эрх бүхий албан тушаалтан хүсэлт гаргасан;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжид заасан тайлагналын үүргийн хүрээнд;
- Хэрэглэгчийн зээлжих чадварыг тодорхойлох зорилгоор Зээлийн мэдээллийн санд;
- Хуульд заасан бусад тохиолдолд.

4.4. Дараах гуравдагч этгээдүүд Аппликейшний ашиглалтын статистик боловсруулах зорилгоор Хэрэглэгчийн зарим мэдээллийг цуглуулж болно:

- Firebase (Google) болон түүнтэй адилтгах мобайл аналитик, crash-reporting үйлчилгээ үзүүлэгч;
- Apple App Store / Google Play — Аппликейшнийг татаж авах, суулгах явцад платформын үйлчилгээ үзүүлэгчийн цуглуулдаг татан авалтын мэдээлэл.

4.5. ББСБ Хэрэглэгчийн мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулах тохиолдолд тухайн этгээдээс энэхүү Нууцлалын бодлого, мэдээллийн аюулгүй байдлын шаардлага, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг шаардана.

Тав. Мэдээллийг нийтэд ил болгох нөхцөл

5.1. Хэрэглэгчийн хувийн мэдээллийн халдашгүй байдлыг хангах хүрээнд ББСБ мэдээллийг нийтэд ил болгох арга хэмжээ авахгүй. Хуульд заасан тохиолдолд зөвхөн төрийн эрх бүхий байгууллагын шаардлагаар мэдээллийг нийтэд ил болгоно.

Зургаа. Мэдээллийн нууцлал, хадгалалт, аюулгүй байдал

6.1. ББСБ Хэрэглэгчийн Апп-д оруулсан мэдээллийг хамгаалалт бүхий системд хадгална. Апп-д нэвтрэх нууц үгийг зөвхөн Хэрэглэгч мэдэх бөгөөд ББСБ уг нууц үгийг шифрлэн кодчилж хадгална.

6.2. ББСБ Хэрэглэгчийн мэдээллийн бүрэн бүтэн байдал алдагдах, зөвшөөрөлгүй нэвтрэх эрсдэлийг бууруулах үүднээс шифрлэлт, сүлжээний хамгаалалт, лог хяналт, эрхийн түвшний хандалт, тогтмол аудит, мониторинг зэрэг арга хэмжээг авч ажиллана.

6.3. Мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын хэрэгжилт, хяналтыг ББСБ-ын эрсдэлийн удирдлагын газар болон мэдээллийн аюулгүй байдал хариуцсан нэгж/ажилтан хариуцан ажиллана.

6.4. Хэрэглэгчийн мэдээллийг хуульд заасан хугацаанаас багагүй хугацаагаар, мөн тухайн мэдээллийг ашиглах шаардлагагүй болтол ББСБ-ын дотоод архивын болон мэдээллийн аюулгүй байдлын журмын дагуу хадгалж, устгана.

6.5. Хэрэв Хэрэглэгч өөрийн хайхрамжгүй үйлдлээс болж нэвтрэх мэдээллээ алдсан, эсхүл өөрийн мэдээллийг бусдад шилжүүлсэн, ашиглуулсан тохиолдолд үүсэх хохирлыг Хэрэглэгч өөрөө бүрэн хариуцна.

6.6. Хэрэглэгч өөрийн бүртгэлд гуравдагч этгээд зөвшөөрөлгүй нэвтэрснийг илрүүлсэн, эсхүл өөрийн хувийн мэдээлэл алдагдсан, зөвшөөрөлгүй ашиглагдсан гэж үзэх үндэслэлтэй болсон тохиолдолд энэ тухайгаа ББСБ-д нэн даруй info@mandalcredit.mn и-мэйл хаягаар мэдэгдэх үүрэгтэй.

6.6. Интернет, и-мэйл, мессенжер зэрэг цахим сувгаар дамжуулж буй мэдээллийн нууцлалыг бүрэн хамгаалах нь техникийн шинж чанараасаа шалтгаалан ББСБ-ын ганцаарчилсан хяналтаас гадуур байдаг тул Хэрэглэгч эдгээр сувгаар мэдээллээ дамжуулахдаа өөрийн болгоомжлолыг хангаж, аюулгүй байдлаа өөрөө анхаарах шаардлагатай.

6.7. Кибер халдлага, системийн доголдол, ажилтны буруутай үйлдэл, эсхүл программ хангамж, мэдээллийн санд гэмтэл гарсны улмаас Хэрэглэгчийн мэдээлэл алдагдсан нь тогтоогдвол ББСБ Хэрэглэгчийн бүртгүүлсэн и-мэйл хаяг, гар утасны дугаар руу нэн даруй мэдэгдэл илгээнэ. Хэрэглэгч уг мэдэгдэлд заасан зааврыг дагаж, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах үүрэгтэй.

Долоо. Насанд хүрээгүй хүний хувийн мэдээллийг хамгаалах

7.1. ББСБ 18 насанд хүрээгүй иргэний мэдээллийг зориудаар цуглуулж, боловсруулж, ашиглаж, хадгалахгүй бөгөөд ийм тохиолдол илэрсэн даруй Үйлчилгээг шуурхай зогсоож, холбогдох мэдээллийг устгах арга хэмжээ авна.

Найм. Хэрэглэгчийн эрх

8.1. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хэрэглэгч дараах эрхийг эдэлнэ:

- Өөрийн мэдээллийг боловсруулах, дамжуулах, ашиглахыг Нууцын бодлогод заасны дагуу ашиглахыг шаардах;
- Аппликейшн дахь өөрийн хувийн мэдээлэлтэй танилцах;
- Хуульд заасан үндэслэлээр мэдээллээ засварлуулах, шинэчлүүлэх, идэвхигүй болгуулахыг шаардах эрх;
- Өөрийн хувийн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд Мэдээлэл хариуцагчид мэдэгдэх;
- Аппликейшний камер, байршил, мэдэгдэл зэрэг зөвшөөрлийг төхөөрөмжийн тохиргооноос хэдийд ч цуцлах эрх.

8.2. Хэрэглэгч хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах зөвшөөрлөө цуцлах хүсэлтээ ББСБ-ын info@mandalcredit.mn и-мэйл хаягаар гаргаж болно. ББСБ нь хүсэлтийг хүлээн авснаас хойш

хуанлийн 30 (гуч) хоногийн дотор холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэж, хариуг Хэрэглэгчид мэдэгдэнэ.

8.3. Хэрэглэгч хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах зөвшөөрлөө цуцалснаас хойш ББСБ уг мэдээллийг цаашид боловсруулахгүй, ашиглахгүй, дахин цуглуулахгүй. Харин хуулиар хадгалахыг үүрэг болгосон мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаагаар үргэлжлүүлэн хадгална.

Ес. Хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй байдлын зөвлөмж

9.1. Хэрэглэгч өөрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд дараах зөвлөмжийг баримтална уу:

- Car Zeel Аппликейшнийг зөвхөн албан ёсны Google Play Store болон App Store-с татан авч ашиглах, хөгжүүлэгчийн нэрийг шалгах;
- Бүртгэлтэй утасны дугаарт илгээгдсэн Баталгаажуулах кодыг хэн нэгэнд, тэр дундаа ББСБ-ын ажилтан гэж өөрийгөө танилцуулсан этгээдэд ч задруулахгүй байх;
- Нэвтрэх нууц үгийг дахин давтагдашгүй байдлаар үүсгэж, бусад үйлчилгээний нууц үгтэй ижил ашиглахгүй байх, тоо, үсгийг хослуулан хэрэглэх, бичиж хадгалахгүй байх;
- Гар утасныхаа дэлгэц түгжих код, хурууны хээ, нүүр таних зэрэг хамгаалалтын тохиргоог идэвхжүүлэх;
- Гар утасны үйлдлийн систем болон Car Zeel Аппликейшнийг тогтмол шинэчилж байх;
- Нээлттэй, баталгаажуулалтгүй Wi-Fi сүлжээг ашиглан хувийн болон санхүүгийн мэдээлэл оруулахаас зайлсхийх;
- Car Zeel-ийн нэрийг ашиглан нэг удаагийн баталгаажуулах код (OTP), нууц үг болон бусад нууц мэдээлэл хүссэн дуудлага, мессеж хүлээн авсан тохиолдолд хариу үйлдэл үзүүлэхгүйгээр ББСБ-д нэн даруй мэдэгдэх;
- Хэт бага хүү, баталгаатай зээл зэрэг бодит бус амлалт бүхий танихгүй аппликейшн, цахим хуудас ашиглахаас зайлсхийж, зээлийн нөхцөл, мэдээллийг зөвхөн ББСБ-ын албан ёсны сувгаар шалгах;
- Гар утсаа бусдад ашиглуулахгүй байх бөгөөд ашиглуулах шаардлагатай тохиолдолд Car Zeel Аппликейшнээс гарах (Log out) эсхүл нэмэлт хамгаалалтын тохиргоо ашиглах.

Арав. Гуравдагч этгээдийн вебсайт, холбоос

10.1. Апп нь ББСБ-тай хамтран ажилладаг гуравдагч этгээдийн вебсайт, үйлчилгээ рүү шилжих холбоосыг агуулж болох бөгөөд эдгээр нь ББСБ-ын хяналтаас гадуур байх тул тэдгээр гуравдагч талын контенттой холбоотойгоор ББСБ хариуцлага хүлээхгүй.

Арван нэг. Нууцлалын бодлогын шинэчлэлт

11.1. ББСБ үйлчилгээг үзүүлж байх хугацаанд шинэ функц нэмэгдэх, хэрэглэгчийн санал, хууль тогтоомжийн өөрчлөлттэй холбогдуулан Нууцлалын бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй ба өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлд орсон өөрчлөлтийг дагаж мөрдөнө.

11.2. ББСБ Нууцлалын бодлогод нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд Car Zeel Аппликейшний Үйлчилгээний нөхцөлд заасантай ижил журмаар буюу Car Zeel Аппликейшнээр дамжуулан Хэрэглэгчид

мэдэгдэнэ. Хэрэглэгч мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 (арав) өдрийн дотор татгалзаагүй тохиолдолд өөрчлөлтийг хүчин төгөлдөр гэж үзнэ.

11.3. Хэрэглэгч болон мэдээлэл хариуцагчийн хооронд маргаан үүссэн тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомж, Car Zeel Аппликейшний Үйлчилгээний нөхцөл болон энэхүү Нууцын бодлогыг баримтална.

**ЭНЭХҮҮ НУУЦЛАЛЫН БОДЛОГОТОЙ БҮРЭН ТАНИЛЦСАН БА ТҮҮНИЙ НӨХЦӨЛИЙГ
ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БАЙНА.**